

ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Н.Дамдиндорж*, **Б.Сайнжаргал****, **Г.Цогтбилэг***¹**,

Хураангуй: Даатгалын салбар нь сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байгаа салбаруудын нэг юм. Тиймээс энэ салбарын санхүүгийн дундаж үзүүлэлтүүдийг тодорхойлж, салбарт үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг тодорхой шалгуураар өрсөлдүүлэн сонгогдсон компаниудын санхүүгийн үзүүлэлтүүдийг салбарын дундажтай харьцуулсан шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх санал дүгнэлтийг өгөхийг зорьсон.

Түлхүүр үг: даатгалын салбар, салбарын дундаж, сонгогдсон компани, санхүүгийн үзүүлэлт, харьцуулсан шинжилгээ

Оршил

Монгол улсын санхүүгийн зах зээлийн салшгүй нэг хэсэг болсон даатгалын салбарын үүсэл хөгжил тэртээ 1934 онд БНМАУ-ын СНЗ-ийн³³ тоот тогтоолоор даатгалын албыг “Улсыг аюулаас хамгаалах газар” нэртэйгээр Сангийн Яамны бүтцийн нэгж болгон байгуулсан байдаг. Монгол Улсын Их Хурал 1997 оны 12-р сарын 05-ны өдөр “Даатгалын тухай” хуулийг батлан гаргасан ба тус хуулийн шинэчилсэн найруулгыг 2004 оны 04-р сарын 30-ны өдөр баталж, үүнтэй холбоотойгоор “Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай” хууль болон “Санхүүгийн Зохицуулах Хорооны” хуулиудыг 2004-2005 онуудад батлан гаргаж, дагаж мөрдүүлснээр арилжааны даатгалын зах зээлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн зах зээлд өөрийн гэсэн байр суурийг нэмэгдүүлж шинэ түвшинд үйл ажиллагаагаа эрхлэн явуулах таатай нөхцлийг бүрдүүлсэн юм. Эдүгээ, Монголын даатгалын зах зээл дээр Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авч даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын 17 компани, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулж байгаа зуучлагч 30 компани, даатгалын хохирол үнэлэгч 20 компани, мэргэжлийн актуарч 15,

*МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail) maidaa0055@yahoo.com

**МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail)

***МУИС-ийн, Бизнесийн сургууль, (E-mail) getso5@yahoo.com

даатгалын төлөөлөгчид 3260 хүн тус тус ажиллаж байна.

Нэг. Монгол улсын даатгалын салбарын оноогийн төлөв байдлын судалгаа

Монгол улсын даатгалын зах зээлд 2014 оны эцсийн байдлаар даатгалын нийт 17 компани ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа явуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагад даатгалын үйлчилгээ үзүүлж байна. Даатгалын үйлчилгээ үзүүлж байгаа компаниудын тоо 2009-2014 оны хооронд харьцангуй тогтмол байна. Дэлхийн улс орнуудын даатгалын салбарын статистикийг судалж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Улс орнуудын хураамжийн орлогын үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хөгжингүй орнууд	Хөгжиж буй орнууд	Харьцуулж болох улс	
				Казакстан	Польш
1	1 хүнд ногдох хураамжийн орлого	5,300,000-6,300,000₮	900,000-1,800,000₮	150,000₮	900,000₮
2	ДНБ-д эзлэх хураамжийн орлогын хувь	2.5-9.5 хувь	1-4 хувь	0,32 хувь	1,83 хувь
3	Нийт хураамжийн орлого			2,640.0 тэрбум₮	34,400.0 тэрбум₮


Эх сурвалж: *International Insurance Fact Book 2016*²

Манай улсын нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого 2009 онд 7,977 төгрөг байсан нь 2014 оны байдлаар 36,333 төгрөг болж 4,5 дахин өссөн боловч бусад орнуудын үзүүлэлтэй харьцуулахад доогуур байна.

Манай улсын даатгалын компаниудын эрсдэл даах чадварыг хангах зорилгоор дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоосонтой холбоотойгоор салбарын нийт хөрөнгө сүүлийн 6 жилд 3,6 дахин буюу жилд дунджаар 30 хувь /21.2 тэр бум төгрөг/-аар өссөн нь чамлахааргүй үзүүлэлт юм.

² “International Insurance Fact Book 2016”, Insurance Information Institute, www.iii.org


Дүрслэл 1. Салбарын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн өсөлт /сая төгрөгөөр/



Эх сурвалж: www.frc.mn

Нийт хөрөнгийн өсөлтийн 81.8 хувь буюу 17.4 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгийн өсөлт тэр тусмаа 45 хувийг мөнгөн хөрөнгийн, 20 орчим хувийг богино хугацаат хөрөнгө оруулалтын өсөлт эзэлж байгаа нь даатгалын салбарын хөрөнгийн хөрвөх болон төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой онцлог гэж болно. Харин бусад салбар (жишээ нь: Уул уурхайн салбар)-т үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын нийт хөрөнгийн багадаа л 50 хувийг³, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт түүнээс ч их хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлдэг байхад даатгалын үйлчилгээний хувьд эргэлтийн бус хөрөнгө төдийлөн чухал бус гэдгийг харуулж байна.


Дүрслэл 1.1 Салбарын хөрөнгийн бүтэц



3 “Уул уурхайн компаниудын санхүүгийн төлөв байдлын шинжилгээ, дүгнэлт”, Бизнес ба инноваци, 2015/02(01)

Хөрөнгийн бүтцийн судалгаагаар тус салбарын эргэлтийн бус хөрөнгийн хувийн жин 2009 онд 12 хувь байсан нь 2014 онд 16,5 хувь болж ерөнхийдөө өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ судалгааны ажилд даатгалын компаниудын хөрөнгийн эх үүсвэрийн бүтцийг өр төлбөр, нөөц сан, хуримтлагдсан ашиг, эзэмшигчийн өмчийн бусад хэсэг (хувьцаат капитал, НТК, дахин үнэлгээний нэмэгдэл, бусад) гэсэн үзүүлэлтүүдээр ангилан судаллаа.

Дүрслэл 2. Салбарын эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/




Эх сурвалж: www.frc.mn

Хуримтлагдсан ашиг нь тухайн компанийн үндсэн үйл ажиллагааны үр дүнг илэрхийлдэг учраас эзэмшигчийн өмчөөс тусад нь салгаж харуулсан бөгөөд 2009-2011 онд хувийн жин нь 5,3 хувиас 14,2 хувь болж өсөж байсан нь сүүлийн 3 жилд нийт эх үүсвэрийн дүнд дөнгөж 3,5 хувь болтолоо, мөнгөн дүнгээр 2 дахин буурсан. Харин эзэмшигчийн өмчийн бусад хэсэг энэ хугацаанд 6 дахин өссөн нь даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосонтой шууд холбоотой⁴ байна. Хурамтлагдсан ашгийн энэ бууралт нь магадгүй даатгалын салбарын өгөөж буурч байгааг илтгэж болох боловч даатгалын компаниудаас сүүлийн 6 жилд үйл ажиллагаагаа зогсоосон, санхүүгийн хүндрэлд орсон компани гараагүй байна.

⁴“Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай”, Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол, 2009, 2011 он

Дүрслэл 2.1 Салбарын эх үүсвэрийн бүтэц




Ийнхүү 2009-2014 онд салбарын нийт эх үүсвэр 3,7 дахин, үүнээс хувь нийлүүлсэн өмчийн дүн 6 дахин, өр төлбөрийн дүн 5,1 дахин, нөөц сангийн үлдэгдэл 2014 онд 64 тэрбум төгрөг болж 2,6 дахин өссөн атал хуримтлагдсан ашгийн хувийн жин он дараалан буурсаар байгаа нь анхаарал татахаар байна. Санхүүгийн байдлын тайлангийн дэлгэрэнгүйг *Хавсралт хүснэгт 1.1-ээр* хавсаргав.

Даатгалын компаниудын орлого хураамжийн болон хураамжийн бус орлогоос бүрдэх бөгөөд эдгээр орлогуудын нийлбэрийг даатгалын орлого болгон тооцдог. Сүүлийн 6 жилд даатгалын орлого 4,5 дахин, даатгалын нөхөн төлбөр 5,6 дахин, үйл ажилгааны зардал 5 дахин, нөөц сан 2,4 дахин өссөн боловч цэвэр ашиг 2014 онд 1,987 сая төгрөг болж 2009 онтой харьцуулахад 20 хувиар буурсан төдийгүй цэвэр ашгийн даатгалын орлогод эзлэх хувийн жин 2009 онд 13.0 хувь, 2010 онд бүр 18,3 хувь байсан нь жил дараалан буурсаар 2014 онд дөнгөж 2,3 хувь болсоноос үзвэл 2009-2014 онд даатгалын компаниудын ашигт ажиллагаа буурсныг харуулж байна.

2009-2014 онд нөхөн төлбөр болон үйл ажилгааны зардалын даатгалын орлогод эзлэх хувийн жин жил дараалан өсөж, харин цэвэр ашиг болон нөөц сангийн даатгалын орлогод эзлэх хувийн жин жилээс жилд буурсан байна.


Дүрслэл 3. Салбарын орлогын тайлангийн үзүүлэлтүүд/сая төгрөгөөр/



Эх сурвалж: www.frc.mn

Өөрөөр хэлбэл 2014 оны байдлаар даатгалын компаниуд 10 төгрөг тутмын 5 төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 3,5 төгрөгийг нөхөн төлбөрт, 1 төгрөгийг нөөц санд хуримтлуулж, үлдэгдэл 0,5 төгрөгөөс татвар төлж, өгөөж хүртэж байна. Тиймээс даатгалын компаниудын цэвэр ашгийн бууралт үйл ажиллагааны зардал болон нөхөн төлбөрийн өсөлтөөс шууд хамааралтай бөгөөд даатгалын зарим бүтээгдэхүүний эрсдэл өндөр болсон (жишээлбэл “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал”⁵) бас даатгалын компаниуд бүтцийн хувьд хэт томорсон, хураамжийн орлогоос байгуулсан нөөц сангийн дүнгээр татвараас чөлөөлөгдөж, тэр нь дараа онууддаа орлогод тооцогдож хуримтлагдсан ашигт шилжин тооцогддоггүй зэрэг хүчин зүйлүүдтэй холбоотой гэж болохоор байна.

Дүрслэл 4. Үзүүлэлтийн даатгалын орлогод эзлэх хувь



5“Жолоочийн даатгалын тухай” хууль, 2012 он


Даатгалын компаниудын цэвэр ашгийн даатгалын орлогод эзлэх хувийн жин 2009-2011 онд 13 хувь өсөлтэй байснаа сүүлийн 3 жилд тасралтгүй буурч байгаад дүгнэлт хийж, татвар ногдуулах журмыг эргэн харах нь зохимжтой байж болох юм. Үүнээс гадна хураамжийн орлогын 4 төгрөг тутмын 1 төгрөг нь гадны давхар даатгалын компанид шилжиж байгааг давхар даатгалаас авч буй нөхөн төлбөрийн дүнтэй зэрэгцүүлэн судалж дотооддоо давхар даатгалын компани үүсгэн байгуулах боломж, бас болзошгүй эрсдлийг судалж үзэх хэрэгтэй. Орлогын тайлангийн дэлгэрэнгүйг *Хавсралт хүснэгт 1.2*-аар хавсаргав.

Нөөц сан нь тайлант хугацааны хураамжийн орлогоос байгуулагдаж, урт хугацаат өр төлбөрт хуримтлагдан бүртгэгддэг бөгөөд ердийн даатгалын компанийн өмнөх тайлант жилийн нөөц санд хамаарах эрсдэл нь тэр жилдээ дуусдаг. Тиймээс хоёр буюу түүнээс өмнөх жилүүдэд байгуулсан зарцуулагдаагүй нөөц санг дараагийн тайлант хугацааны цэвэр орлоготой адилтган тооцож, тайлант жилийн орлого үр дүнг тодорхойлох хувилбар байхыг үгүйсгэхгүй.

Хоёр. Даатгал зарим компаниудыг салбарын дундажтай харьцуулсан шинжилгээ


Даатгалын салбарт ердийн даатгалын 16 компани, урт хугацааны даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ердийн даатгалын 16 компаниас даатгалын салбарын чухал 10 үзүүлэлтээр өрсөлдүүлэн зах зээлийн тэргүүлэгч, дундаж болон бага хувийг эзэлж байгаа 3 компанийг сонгон авч, салбарын дундажтай нь харьцуулсан шинжилгээ хийсэн.

Дүрслэл 5. Даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувь



Энэ 3 компанийг сонгохдоо 2009-2014 онуудад тасралтгүй үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт хураамжийн орлого, цэвэр хураамжийн орлого, нөхөн төлбөр, хураамжийн бус орлого, үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/, цэвэр ашиг /алдагдал/, нийт хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, нөөц сан, хуримтлагдсан ашиг гэсэн үзүүлэлтийг сонгож, үзүүлэлт бүрт тэнцүү ач холбогдол өгч компаниудын зах зээлд эзлэх хувийг *Дүрслэл 5*-аар тодорхойлоход “Монгол Даатгал” ХХК нь даатгалын салбарын 17 хувийг эзэлж байгаа бөгөөд салбарт тэргүүлэгч компаниар, “Практикал Даатгал” ХХК нь даатгалын салбарын 7,1 хувийг эзэлж дундаж компаниудын төлөөлөл, харин “Мөнх Даатгал” ХХК нь даатгалын салбарын 1,4 хувийг эзэлж, энэ салбарын хамгийн жижиг компанийн төлөөлөл болж сонгогдлоо. Энэ 3 компанийг (цаашид “сонгогдсон компаниуд”) салбарын дундажтай харьцуулан судалж, өөрийн санал дүгнэлтийг өгөхийг зорисон юм. Даатгалын компаниудын зах зээлд эзлэх хувийн дэлгэрэнгүй тооцооллыг *Хавсралт хүснэгт 2*-аар үзүүлэв. Сонгосон 3 компанийн хөрөнгө ба эх үүсвэрийн бүтцийн үзүүлэлтийг салбарын дундажтай нь зэрэгцүүлэхэд (*Дүрслэл 6*): Салбарын дүнгээр эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувийн жин 84 хувь гэж гарсан ба сонгогдсон компанийн эргэлтийн хөрөнгийн хувийн жин “Мөнх Даатгал” ХХК-ийн 2012 оны үзүүлэлтийг эс тооцвол бүх онуудад салбарын дунджаас бага, харин эргэлтийн бус хөрөнгийн хувийн жин салбарын дунджаас өндөр байжээ.


Дүрслэл 6.1 Салбарын дунджийн харьцуулалт



Тухайлбал “Монгол даатгал” ХХК-ийн эргэлтийн хөрөнгийн хувь оролцоо 2011 оноос эхлэн салбарын дунджаас доошилсон байгаа нь дүрмийн сангийн доод хэмжээг хангахын тулд тус компанийн эзэд эргэлтийн бус хөрөнгийн


болон хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой бөгөөд энэ нөлөөлөөр эргэлтийн бус хөрөнгийн болон эздийн өмчийн бусад хэсгийн эх үүсвэрийн дүнд эхлэх хувь зэрэг өссөн. Харин “Практикал Даатгал” ХХК-ийн хөрөнгийн бүтцийн үзүүлэлтүүд 2009-2014 онд харьцангуй тогтвортой байсан.

Дүрслэл 6.2 Салбарын дунджийн харьцуулалт



“Монгол Даатгал” ХХК-ийн нөөц сангийн нийт эх үүсвэр эзлэх хувь салбарын дундажаас харьцангуй дээгүүр, харин хуримтлагдсан ашгийн нийт эх үүсвэрт эзлэх хувь буурсаар байгаа нь энэ компани тайлант хугацааны хураамжийн орлогоос нөөц санг салбарын дундажаас өндөр хувиар байгуулж ирснийг илтгэж байна.

Дүрслэл 6.3 Салбарын дунджийн харьцуулалт



“Мөнх Даатгал” ХХК нь нөөц санг салбарын дундажаас бага хувиар байгуулж ирсэний нөлөөгөөр хуримтлагдсан ашгийн хувь нь салбарын дундажийн хэмжээнд хадгалагдсан байна. Харин “Практикал Даатгал” ХХК-ийн нь нөөц сангийн эх үүсвэрт эзлэх хувь нь салбарын дундажтай тэнцүү бөгөөд хуримтлагдсан ашгийн түвшин нь даатгалын бусад компаниудаас тогтвортой дээгүүр байна. Нөөц сан болон хуримтлагдсан ашиг гэсэн үзүүлэлтүүд нь тухайн компанийн татвар төлөлтийн идэвхийг харуулж байгаа үзүүлэлт юм. Салбарын дундажаар нийт хөрөнгийн гуравны нэг нь эздийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн байдаг бол “Мөнх Даатгал” ХХК-ийн нийт

хөрөнгийн гуравны хоёр нь эздийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн байгаа нь даруй 2 дахин илүү болж жижиг компаниудын хувьд (жишээлбэл “Мөнх Даатгал” ХХК) дүрмийн сангийн доод хэмжээг өсгөсөн нь хүндрэлтэй байгааг илтгэж байна. Судалгаанд хамрагдсан хугацаанд сонгогдсон компаниудын нийт хураамжийн орлогод эзлэх цэвэр хураамжийн орлогын хувь “Монгол Даатгал” ХХК-ийн 2014 оны үзүүлэлтээс бусад бүх үзүүлэлт салбарын дундаж (73 хувь)-аас их байгаа (“Монгол Даатгал” ХХК-80 хувь, “Практикал Даатгал” ХХК-91 хувь, “Мөнх Даатгал” ХХК-100 хувь) нь даатгалын компанийн үйл ажиллагаа тэлэхийн хэрээр эрсдлийг бууруулах зорилгоор давхар даатгалын үйлчилгээг сонгох хандлага ажиглагдаж, тэр нь цэвэр хураамжийн орлогыг бууруулахад хүргэж байна. “Монгол Даатгал” ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны ашгийн түвшин салбарын дунджаас бага боловч 2010-2013 онуудад харьцангуй тогтвортой байсан. 2014 оны ашгийн түвшний бууралт нь даатгалын орлогын бууралт, нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардлын өсөлттэй хамааралтай юм. “Практикал Даатгал” ХХК-ийн нөхөн төлбөр болон үйл ажиллагааны зардлын өсөлт даатгалын орлогын өсөлт болон нөөц сангийн бууралтаас давсан учраас ашгийн түвшин 2009-өөс 2013 он хүртэл буурсаар салбарын дунджаас доош орсон. Харин 2014 оны ашгийн түвшиний өсөлт өмнөх жилүүдтэй харьцуулахад үйл ажиллагааны зардалын бууралттай холбоотой юм. Энэ 2 компанийн хувьд үндсэн үйл ажиллагааны ашиг болон цэвэр ашигийн түвшинд нөлөөлөх хүчин зүйл ижил байгааг *Хүснэгт 3-аас* харж болно. “Мөнх Даатгал” ХХК-ийн ашгийн түвшинд шууд нөлөөлж байгаа үзүүлэлт нь тайлант хугацааны орлогоос байгуулж байгаа нөөц сангийн түвшин бөгөөд үндсэн үйл ажиллагааны ашиг болон цэвэр ашигт нөлөөлөх хүчин зүйл өөр байгааг анзаарах хэрэгтэй.

Хүснэгт 3. Орлогын тайлангийн үзүүлэлтүүдийн харьцуулалт

Үзүүлэлт	Компанийн нэр	2009	2010	2011	2012	2013	2014	Дундаж
Цэвэр хураамжийн орлого	Монгол Даатгал	92.8%	83.8%	94.7%	75.3%	73.9%	60.9%	80.2%
	Практикал Даатгал	94.2%	90.0%	91.6%	86.0%	93.4%	91.8%	91.2%
	Мөнх Даатгал	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
	САЛБАР	74.1%	75.6%	77.2%	72.6%	71.3%	67.6%	73.1%
Нөхөн төлбөр	Монгол Даатгал	39.8%	33.6%	27.1%	32.1%	36.8%	45.6%	35.8%
	Практикал Даатгал	12.1%	13.2%	13.9%	21.8%	39.8%	44.2%	24.2%
	Мөнх Даатгал	37.0%	13.2%	10.0%	14.6%	41.7%	38.5%	25.8%
	САЛБАР	28.2%	24.1%	23.2%	25.3%	33.7%	35.0%	28.3%

Нөөц сан	Монгол Даатгал	9.4%	12.8%	10.9%	6.7%	15.3%	6.4%	10.3%
	Практикал Даатгал	48.4%	22.4%	10.2%	24.0%	5.6%	-0.1%	18.4%
	Мөнх Даатгал	-14.2%	30.1%	45.0%	7.8%	-52.7%	-18.3%	-0.4%
	САЛБАР	16.7%	16.3%	15.4%	17.8%	13.2%	9.1%	14.8%
Үйл ажиллагааны зардал	Монгол Даатгал	64.8%	46.7%	48.2%	51.4%	46.9%	53.1%	51.9%
	Практикал Даатгал	26.9%	26.0%	34.7%	37.0%	55.4%	51.1%	38.5%
	Мөнх Даатгал	70.9%	46.2%	46.9%	77.7%	103.0%	103.5%	74.7%
	САЛБАР	48.6%	40.6%	41.5%	44.5%	49.7%	52.4%	46.2%
Үндсэн үйл ажиллагааны ашиг	Монгол Даатгал	-14.1%	14.4%	13.8%	9.8%	1.0%	-5.1%	3.3%
	Практикал Даатгал	12.5%	36.6%	41.2%	17.3%	-0.8%	4.8%	18.6%
	Мөнх Даатгал	6.2%	10.4%	-1.8%	0.0%	8.1%	-23.8%	-0.1%
	САЛБАР	6.5%	21.3%	19.8%	12.4%	3.5%	3.5%	11.2%
Цэвэр ашиг	Монгол Даатгал	3.9%	13.5%	18.6%	8.9%	3.5%	-6.1%	7.0%
	Практикал Даатгал	17.7%	28.5%	39.0%	16.1%	-0.8%	4.3%	17.5%
	Мөнх Даатгал	5.6%	13.8%	11.1%	18.5%	18.2%	15.4%	13.8%
	САЛБАР	13.0%	18.3%	19.9%	10.1%	6.2%	2.3%	11.6%

Эх сурвалж: www.frc.mn

Өөрөөр хэлбэл “Мөнх Даатгал” ХХК-ийн үндсэн бус үйл ажиллагаанаас олж байгаа ашиг цэвэр ашгийг 2009-2014 онд тогтмол өсгөсөн байна. Үндсэн бус үйл ажиллагааны ашигт торгууль хөнгөлөлтийн, ногдол ашгийн, валютын ханшны өөрчлөлтийн, хараат болон хамтарсан үйлдвэрээс олсон, бусад гэх мэт үйл ажиллагааны олж байгаа ашиг алдагдал хамаарна. Өмнөх 2 компани үндсэн бус үйл ажиллагаагаар ашиг олж байгаа боловч абсолют утгаараа материаллаг бус учраас цэвэр ашигт нөлөөлж чадахгүй байж болох юм. Сонгогдсон компаниудын санхүүгийн харьцаануудыг салбарын дундажтай зэрэгцүүлэхэд бүх үзүүлэлтээрээ хувьд “Практикал Даатгал” ХХК нь салбарын дундажтайгаа хамгийн ойролцоо, “Монгол Даатгал” ХХК-ийн ашигт ажиллагааны түвшингээс бусад үзүүлэлтүүд нь салбарын дунджаас харьцангуй доогуур байгаа нь тухайн компанийн төлбөрийн чадвар болоод санхүүгийн тогтвортой байдал цаашдаа сулрах хандлага ажиглагдаж байна. Тиймээс “Монгол Даатгал” ХХК-ийн төлбөрийн чадвар болон санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахын тулд тайлант хугацааны хураамжийн орлогоос байгуулж байгаа нөөц сангийн хэмжээг зохистой түвшинд тогтоох, нөхөн төлбөрийн хэмжээг бууруулах зорилгоор эрсдэл ихтэй даатгалын бүтээгдэхүүнээс татгалзах гэх мэтээр хөрөнгийн эх үүсвэрийн бүтцэд анхаарал хандуулах шаардлагатай байна. Харин “Мөнх Даатгал” ХХК-ийн ашигт ажиллагааны түвшингээс бусад үзүүлэлтүүд салбарын дунджаас дээгүүр байгаа нь даатгалын үйл ажиллагаагаа улам бүр идэвхижүүлэх, хураамжийн орлогыг

өсгөх, үйл ажиллагааны зардлыг бууруулах зэрэг гадаад болон дотоод хүчин зүйлд анхаарах хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүргэлээ.

Хүснэгт 4. Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Салбарын дундаж						Монгол даатгал					
		2009	2010	2011	2012	2013	2014	2009	2010	2011	2012	2013	2014
1	Бие даалтын коэффициент	0.32	0.43	0.48	0.50	0.49	0.48	0.05	0.22	0.29	0.28	0.25	0.26
2	Зохицуулалтын коэффициент	0.69	0.63	0.64	0.66	0.73	0.65	-1.2	-0.27	0.35	0.30	0.10	-0.16
3	Нөхөн төлбөрийн чадвар*	6.38	6.67	6.38	5.31	4.18	3.95	4.14	3.84	4.50	3.21	2.55	2.46
4	Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	0.06	0.09	0.11	0.06	0.04	0.01	0.02	0.07	0.12	0.07	0.03	-0.04
5	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	0.20	0.22	0.23	0.12	0.08	0.03	0.41	0.32	0.41	0.24	0.11	-0.15
6	Альтманы индекс	1.46	1.82	2.09	2.05	1.93	1.75	0.60	1.00	1.59	1.55	1.36	0.90
№	Үзүүлэлт	Практикал даатгал						Мөнх даатгал					
		2009	2010	2011	2012	2013	2014	2009	2010	2011	2012	2013	2014
1	Бие даалтын коэф	0.43	0.44	0.56	0.52	0.50	0.50	0.50	0.49	0.67	0.56	0.70	0.82
2	Зохицуулалтын коэф	0.78	0.40	0.56	0.62	0.64	0.66	0.80	0.71	0.59	0.79	0.84	0.70
3	Нөхөн төлбөрийн чадвар*	11.3	9.27	9.39	5.22	3.27	2.90	9.28	20.07	20.32	16.06	11.81	16.38
4	Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	0.12	0.17	0.23	0.11	-0.005	0.03	0.01	0.04	0.04	0.07	0.03	0.02
5	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	0.27	0.38	0.40	0.22	-0.01	0.06	0.03	0.06	0.08	0.10	0.04	0.02
6	Альтманы индекс	2.14	2.18	2.84	2.32	1.56	1.70	1.39	2.34	1.75	2.79	4.00	4.70

*- Эргэлтийн хөрөнгийн дүнг тайлант хугацааны нөхөн төлбөрийн дүнд харьцуулсан

Судалгааны ажлын дүгнэлт:

Даатгалын салбар нь үйлчилгээний онцлогоос хамаараад нийт хөрөнгийн дийлэнх хувийг эргэлтийн хөрөнгө эзэлдэг бөгөөд хөрөнгө нь эздийн хөрөнгө оруулалт болон хураамжийн орлогоос байгуулсан нөөц сангаар санхүүждэг онцлогтой юм байна. Харин үйл ажиллагаанаас олж байгаа орлогын хагас нь үйл ажиллагааны зардалд, гуравны нэг нь нөхөн төлбөрт, 15 орчим хувь нь нөөц сан байгуулахад зарцуулагдаж байна. Сонгогдсон компаниудын хувьд зах зээлд эзлэх байр суурь өсөх тутам ашигт ажиллагаа буурч байгаа нь үйл

ажиллагааны зардлын өсөлттэй зарим талаар холбоотой боловч хамгийн гол нь хураамжийн орлогоос байгуулж байгаа нөөц сангийн хэмжээ бусад компани болон салбарын дунджаас төдийгүй нөхөн төлбөрийн буцаан олголтоос хэд дахин илүү байгаатай холбоотой юм байна. Энэ нь даатгалын салбарт байр суурь нь бэхжсэн компаниуд нөөц сан байгуулах замаар татвар ноогдох орлогоо бууруулдаг байж болзошгүй. Зөвхөн 2009-2014 ондуудад 24 тэрбум төгрөгийн татвар ногдох орлогыг нөөц санд төвлөрүүлсэн нь 1,2 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

	Үзүүлэлт	Хуучин	Шинэ	Зөрүү
1	Даатгалын орлого /Салбар/	273,207,900,860	297,289,955,603	24,082,054,743
2	Нөхөн төлбөр /Салбар/	96,066,786,879	108,107,814,251	12,041,027,372
3	Татварын зардал /Салбар/	5,530,506,347	6,734,609,084	1,204,102,737

Нөөц сангийн энэ хэт их хуримтлал нь хөрөнгийн эх үүсвэрийн бүтэц, ашигт ажиллагаа болон санхүүгийн үзүүлэлтүүдэд нөлөөлж, санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулж байна.

Санал, зөвлөмж:

Өмнөх онуудад байгуулсан нөөц сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийн зохих хэсгийг тогтоосон журмаар тухайн тайлант оны орлого болгон шилжүүлэн тооцох замаар нөөц сангийн хэмжээг зохистой хэмжээнд барих журмыг боловсруулан мөрдөхийг санал болгож байна. Учир нь өмнөх онд байгуулсан нөөц сангийн эрсдэл нэг жилийн хугацаанд хамаардаг. Ийнхүү зарцуулагдаагүй нөөц сангийн зарим хэсгийг тайлант оны ашигт шилжүүлэн тооцсоноор орлогын татвараас зайлсхийх үзэгдэл багасах төдийгүй даатгалын компанийн тайлагналаар санхүүгийн төлөв байдал нь үнэн бодитой тодорхойлогдож, даатгуулагчдын итгэл нэмэгдэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Ашигласан эх сурвалж:

Б.Сайнжаргал, Санхүүгийн тайлангийн шинжилгээ, 1999, Улаанбаатар
 Санхүүгийн зохицуулах хороо, Даатгалын салбарын нэгдсэн үзүүлэлт, 2009-2014
 Санхүүгийн зохицуулах хороо, Ердийн даатгалын компанийн орлогын тайлан, баланс, 2009-2014, Улаанбаатар
 Insurance Information Institute, “International Insurance Fact Book”, 2016
 Уул уурхайн компаниудын санхүүгийн төлөв байдлын шинжилгээ, дүгнэлт”,

Бизнес ба инноваци, 2015/02(01)
 Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай”,
 Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол, 2009, 2011
 Жолоочийн даатгалын тухай” хууль, 2012 он
 Bashir Ahmad Joo, Analysis of Financial Stability of Indian Non Life Insurance
 Companies, 2013
 Glenn Meyers, An Analysis of the Capital Structure of an Insurance Company,
 2014
 Санхүүгийн зохицуулах хороо, www.frc.mn
 Insurance Information Institute, www.iii.org
 Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, www.1212.mn
 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, www.legalinfo.mn

Хавсралт хүснэгт 1.1 Салбарын санхүүгийн байдлын тайлан/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2009		2010	2011	2012	2013	2014		Дундаж өсөлт	
									Хувь	Төгрөг
Нийт хөрөнгө	39,920	100%	100%	100%	100%	100%	146,025	100%	30%	21,221
Эргэлтийн хөрөнгө	35,144	88.0%	82.8%	82.1%	82.5%	86.7%	121,940	83.5%	28%	17,359
Мөнгөн хөрөнгө	23,479	58.8%	59.7%	48.2%	48.2%	59.2%	72,713	49.8%	25%	9,846
Богино хугацааг хөрөнгө оруулалт	6,936	17.4%	14.9%	23.9%	23%	12%	25,326	17.3%	30%	3,677
Эргэлтийн бус хөрөнгө	4,776	12.0%	17.2%	17.9%	17.5%	13.3%	24,085	16.5%	38%	3,862
Эх үүсвэр	39,920	100%	100%	100%	100%	100%	146,025	100%	30%	21,221
Өр төлбөр	2,265	5.7%	4.0%	6.1%	4.8%	3.7%	11,618	8.0%	39%	1,871
Нөөц сан	24,746	62.0%	53.4%	46.2%	44.8%	47.8%	64,809	44.4%	21%	8,013
Хуримтлагдсан ашиг	2,111	5.3%	7.0%	14.2%	7.5%	5.8%	5,161	3.5%	20%	610
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	10,798	27.0%	35.6%	33.6%	42.8%	42.7%	64,437	44.1%	43%	10,728

Эх сурвалж: www.frc.mn

Хавсралт хүснэгт 1.2. Салбарын орлогын тайлан
/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2009		2010	2011	2012	2013	2014		Дундаж өсөлт	
									Хувь	Төгрөг
Даатгалын нийт хураамжийн орлого	23,284	100%	100%	100%	100%	100%	107,305	100%	35.7%	16,804

Даатгалын цэвэр хураамжийн орлого	17,246	74.1%	75.6%	77.2%	72.6%	71.3%	72,524	67.6%	33.3%	11,056
Даатгалын хураамжийн бус орлого	2,299	9.9%	13.6%	13.5%	11.8%	12.5%	15,640	14.6%	46.7%	2,668
Даатгалын орлого	19,545	100%	100%	100%	100%	100%	88,164	100%	35.2%	13,724
Нийтнөхөн төлбөр	5,511	28.2%	24.1%	23.2%	25.3%	33.7%	30,860	35.0%	41.1%	5,070
Нөөц сан	3,267	16.7%	16.3%	15.4%	17.8%	13.2%	7,992	9.1%	19.6%	945
Үндсэн үйл ажиллагааны зардал	9,493	48.6%	40.6%	41.5%	44.5%	49.7%	46,188	52.4%	37.2%	7,339
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	1,273	6.5%	21.3%	19.8%	12.4%	3.5%	3,123	3.5%	19.7%	370
Үндсэн бус үйл ажиллагаа ашиг (алдагдал)	1,573	8.0%	-0.8%	2.5%	-0.5%	4.3%	70	0.1%	-46%	(301)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,846	14.6%	20.5%	22.4%	11.9%	7.7%	3,193	3.6%	2.3%	69
Цэвэр ашиг	2,540	13.0%	18.3%	19.9%	10.1%	6.2%	1,987	2.3%	-4.8%	(111)

Эх сурвалж: www.frc.mn

Хавсралт хүснэгт 2. Зах зээлд эзлэх хувийн тооцоолол

	Үзүүлэлт	МОНРЕ	АРД	БОДЬ	МӨНХ
1	Нийт хураамжийн орлого-10%	0.0027	0.0094	0.0168	0.0005
2	Цэвэр хураамжийн орлого-10%	0.0036	0.0113	0.0111	0.0007
3	Нөхөн төлбөр-10%	0.0038	0.0100	0.0114	0.0006
4	Хураамжийн бус орлого-10%	0.0040	0.0048	0.0257	0.0000
5	Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/-10%	0.0043	0.0097	0.0173	0.0000
6	Цэвэр ашиг /алдагдал/-10%	0.0035	0.0107	0.0004	0.0039
7	Нийт хөрөнгө-10%	0.0039	0.0060	0.0087	0.0029
8	Эргэлтийн хөрөнгө-10%	0.0039	0.0069	0.0082	0.0026
9	Нөөц сан-10%	0.0026	0.0064	0.0107	0.0009
10	Хуримтлагдсан ашиг-10%	0.0038	0.0132	0.0087	0.0021
	Нийт оноо	0.0360	0.0885	0.1190	0.0141
	Нийт оноо %	3.60%	8.85%	11.90%	1.41%
	Үзүүлэлт	МИГ	СОЁМБО	МОНГОЛ	ТЭНГЭР
1	Нийт хураамжийн орлого-10%	0.0086	0.0048	0.0273	0.0076
2	Цэвэр хураамжийн орлого-10%	0.0097	0.0065	0.0246	0.0088
3	Нөхөн төлбөр-10%	0.0095	0.0057	0.0302	0.0069
4	Хураамжийн бус орлого-10%	0.0072	0.0041	0.0165	0.0081

5	Үндсэн үйл ажиллагааны ашиг / алдагдал/-10%	0.0105	0.0000	0.0000	0.0152
6	Цэвэр ашиг /алдагдал/-10%	0.0082	0.0000	0.0000	0.0150
7	Нийт хөрөнгө-10%	0.0070	0.0062	0.0224	0.0077
8	Эргэлтийн хөрөнгө-10%	0.0067	0.0052	0.0188	0.0083
9	Нөөц сан-10%	0.0074	0.0057	0.0302	0.0095
10	Хуримтлагдсан ашиг-10%	0.0106	0.0000	0.0000	0.0103
	Нийт оноо	0.0855	0.0382	0.1700	0.0975
	Нийт оноо %	8.55%	3.82%	17.00%	9.75%
	Үзүүлэлт	НОМИН	УЛААНБААТАР	ГЭР	ГАН ЗАМ
1	Нийт хураамжийн орлого-10%	0.0043	0.0011	0.0003	0.0005
2	Цэвэр хураамжийн орлого-10%	0.0058	0.0017	0.0004	0.0007
3	Нөхөн төлбөр-10%	0.0077	0.0002	0.0003	0.0002
4	Хураамжийн бус орлого-10%	0.0000	0.0023	0.0031	0.0035
5	Үндсэн үйл ажиллагааны ашиг / алдагдал/-10%	0.0000	0.0090	0.0051	0.0126
6	Цэвэр ашиг /алдагдал/-10%	0.0193	0.0083	0.0049	0.0130
7	Нийт хөрөнгө-10%	0.0052	0.0036	0.0027	0.0035
8	Эргэлтийн хөрөнгө-10%	0.0062	0.0040	0.0032	0.0041
9	Нөөц сан-10%	0.0061	0.0019	0.0011	0.0013
10	Хуримтлагдсан ашиг-10%	0.0000	0.0057	0.0058	0.0089
	Нийт оноо	0.0547	0.0378	0.0269	0.0484
	Нийт оноо %	5.47%	3.78%	2.69%	4.84%
	Үзүүлэлт	ПРАКТИКАЛ	МОННИС	МАНДАЛ	ХААН
1	Нийт хураамжийн орлого-10%	0.0043	0.0011	0.0075	0.0032
2	Цэвэр хураамжийн орлого-10%	0.0058	0.0002	0.0047	0.0045
3	Нөхөн төлбөр-10%	0.0077	0.0002	0.0043	0.0014
4	Хураамжийн бус орлого-10%	0.0073	0.0023	0.0088	0.0022
5	Үндсэн үйл ажиллагааны ашиг / алдагдал/-10%	0.0045	0.0061	0.0000	0.0056
6	Цэвэр ашиг /алдагдал/-10%	0.0046	0.0028	0.0000	0.0054
7	Нийт хөрөнгө-10%	0.0057	0.0038	0.0064	0.0044
8	Эргэлтийн хөрөнгө-10%	0.0056	0.0045	0.0072	0.0044
9	Нөөц сан-10%	0.0061	0.0013	0.0050	0.0037
10	Хуримтлагдсан ашиг-10%	0.0192	0.0117	0.0000	0.0000
	Нийт оноо	0.0707	0.0338	0.0440	0.0349
	Нийт оноо %	7.07%	3.38%	4.40%	3.49%

Хавсралт хүснэгт 3. Компаниудын санхүүгийн байдлын тайлан
/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	Дундаж өсөлт			
								Хувь	Төгрөг		
Монгол даатгал	Нийт хөрөнгө	12,640	100%	100%	100%	100%	32,694	100%	21%	4,011	
	Эргэлтийн хөрөнгө	10,457	83%	68%	79%	78%	22,922	70%	17%	2,493	
	Мөнгөн хөрөнгө	8,886	70%	64%	74%	72%	19,800	61%	17%	2,183	
	Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	0%	0%	1%	1%	1,439	4%		288	
	Эргэлтийн бус хөрөнгө	2,183	17%	32%	21%	22%	9,772	30%	35%	1,518	
	Эх үүсвэр	12,640	100%	100%	100%	100%	32,694	100%	21%	4,011	
	Өр төлбөр	1,204	10%	5%	3%	5%	4,656	14%	31%	690	
	Нөөц сан	10,836	86%	73%	67%	67%	19,582	60%	13%	1,749	
	Хуримтлагдсан ашиг	(1,331)	-11%	-6%	9%	10%	7%	(828)	-3%	-9%	101
	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	1,930	15%	28%	20%	19%	18%	9,283	28%	37%	1,471
Практикал даатгал	Нийт хөрөнгө	2,663	100%	100%	100%	100%	8,302	100%	26%	1,128	
	Эргэлтийн хөрөнгө	2,412	91%	73%	75%	81%	82%	6,885	83%	23%	895
	Мөнгөн хөрөнгө	1,613	61%	48%	48%	51%	40%	4,261	51%	21%	530
	Богино хугацаат хөрөнгө оруулалт	95	4%	6%	1%	0%	0%	-	0%	-100%	(19)
	Эргэлтийн бус хөрөнгө	250	9%	27%	25%	19%	18%	1,417	17%	41%	233
	Эх үүсвэр	2,663	100%	100%	100%	100%	100%	8,302	100%	26%	1,128
	Өр төлбөр	16	1%	7%	2%	1%	1%	221	3%	69%	41
	Нөөц сан	1,501	56%	49%	42%	47%	49%	3,925	47%	21%	485
	Хуримтлагдсан ашиг	645	24%	18%	36%	24%	15%	1,406	17%	17%	152
	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	500	19%	26%	20%	27%	35%	2,750	33%	41%	450
Мөнх даатгал	Нийт хөрөнгө	976	100%	100%	100%	100%	4,238	100%	34%	652	
	Эргэлтийн хөрөнгө	879	90%	80%	77%	85%	87%	3,123	74%	29%	449
	Мөнгөн хөрөнгө	867	89%	78%	76%	79%	80%	3,107	73%	29%	448
	Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	0%	0%	0%	1%	0%	-	0%		-
	Эргэлтийн бус хөрөнгө	97	10%	20%	23%	15%	13%	1,115	26%	63%	204
	Эх үүсвэр	976	100%	100%	100%	100%	100%	4,238	100%	34%	652
	Өр төлбөр	141	14%	0%	2%	0%	0%	17	0%	-34%	(25)
	Нөөц сан	355	36%	32%	42%	29%	17%	564	13%	10%	42
	Хуримтлагдсан ашиг	(33)	-3%	2%	6%	7%	4%	156	4%	-236%	38
	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	513	53%	66%	50%	63%	78%	3,500	83%	47%	597

Эх сурвалж: www.frc.mn

Хавсралт хүснэгт 4. Санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Салбар						Монголдаатгал					
		2009	2010	2011	2012	2013	2014	2009	2010	2011	2012	2013	2014
1	Биедаалтынкоэф	0.32	0.45	0.50	0.53	0.52	0.52	0.05	0.25	0.34	0.32	0.29	0.30
2	Зохицуулалтынкоэф	0.69	0.64	0.65	0.67	0.74	0.67	-1.28	-0.16	0.44	0.36	0.19	-0.03
3	Нөхөнтөлбөрийнчадвар	6.38	5.66	5.46	4.57	3.59	3.39	4.14	3.27	3.88	2.74	2.21	2.09
4	Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	0.06	0.10	0.13	0.08	0.07	0.04	0.02	0.05	0.16	0.13	0.09	0.02
5	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	0.20	0.23	0.26	0.16	0.13	0.08	0.41	0.21	0.47	0.39	0.31	0.08
6	Альтманыиндекс	1.47	1.99	2.33	2.33	2.28	2.09	0.60	1.04	1.87	1.92	1.74	1.28

№	Үзүүлэлт	Практикал даатгал						Мөнх даатгал					
		2009	2010	2011	2012	2013	2014	2009	2010	2011	2012	2013	2014
1	Биедаалтынкоэф	0.43	0.48	0.60	0.55	0.55	0.54	0.49	0.69	0.58	0.73	0.86	0.88
2	Зохицуулалтынкоэф	0.78	0.43	0.58	0.64	0.67	0.68	0.80	0.71	0.60	0.79	0.85	0.70
3	Нөхөнтөлбөрийнчадвар	11.36	6.79	6.92	4.46	2.73	2.53	9.28	15.84	14.61	12.41	9.12	13.55
4	Нийтхөрөнгийншигтажиллагаа	0.12	0.23	0.28	0.16	0.06	0.08	0.01	0.06	0.07	0.09	0.07	0.03
5	Өөрийнхөрөнгийншигтажиллагаа	0.27	0.49	0.46	0.29	0.11	0.15	0.03	0.09	0.12	0.13	0.08	0.04
6	Альтманыиндекс	2.14	2.58	3.25	2.64	2.07	2.12	1.39	2.53	1.96	3.11	5.04	5.35